



ТӨГСӨГЧДӨД ГАРДУУЛАХ ЗАХИА ДААЛГАВАР

Монгол Улсын ууган Их сургуулийг амжилттай төгсөж байгаа Та нартаа МУИС-ийн Захиргаа, Эрдмийн зөвлөл, эрдмийн хамт олон халуун баяр хүргэж байна.

Та өөрийн хичээл зүтгэл, эрдэмтэн багш нарын сургах их үйлсийн ачаар МУИС-ийг төгсөж дээд боловсрол эзэмшлээ.

Хожмын амьдралдаа эрхэмлэж явах хэдэн зүйлийг Та нартаа захиж байна. Та бүхэн төрөлх сургуулийнхаа зүгээс захиж байгаа даалгавар хэмээн байнга санаж, хэрэгжүүлж яваарай.

Та иргэнийхээ үүргийг ухамсарлаж явах ёстой.

Энэ мөчөөс эхлэн таныг өөртөө байгаа сайн сайхан бүхнийг эх орондоо зориулж, ард түмнийхээ түүхэн замналын хуудсыг бичилцэх эрхэм дээд бахархалтай үүрэг хүлээж байна.

Эх орныхоо өмнө хүлээсэн ариун үүргээ Та нэр төртэй биелүүлж чадна гэдэгт бид эргэлзэхгүй байна.

Та амьдралд идэвхтэй байр суурийг эзэлж байх ёстой.

Амьдралын бахдал болсон үүргээ биелүүлэхийн тулд зөвхөн тэргүүний мэргэжилтэн байх төдийгүй Та салбартаа тэргүүлэгч, манлайлагч, санаачлагч байж, өөрийгөө байнга хөгжүүлж, боловсруулж байх ёстой. Ингэж гэмээн та эх орныхоо хэрэгцээт иргэн байх үүргийг гүнээ ухамсарлах болно.

Та зорилго тэмүүлэлтэй байх ёстой.

Таны ажил, амьдралын хөдөлгөгч хүч нь юунд ч саатахгүй бадрангуй тэмүүлэл, уужуу тайван сэтгэл, тасралтгүй суралцаж байх чанар гэдгийг битгий мартаарай. Сэтгэлээр сайхан яваа хүний хөл нь бүдрэхэд тэмүүлэл, мөрөөдөл нь түшээд авдаг юм.

Та ямар нэгэн ажлыг бүтээе гэж үнэхээр бадрангуй тэмүүллээр зориглож чадвал таны тавьсан зорилгын тал хувь нь бүтсэнтэй ялгаагүй гэж эрдэмтэд тун онож хэлсэн байдгийг санаж яваарай. Мөрөөдөлдөө итгэж чин сэтгэлээр туйлбартай зүтгэх чанар бүхэн танд бий.

Та хойч үеэ хүмүүжүүлэх ёстой.

Та болон таны дараагийн хойч үеийн залуучуудын өмнө ахмад үеийн бүтээсэн нийгмийн гайхамшигтай их баялгийг үргэлжлүүлэх, цэцэглүүлэн хөгжүүлэх, Монгол орныхоо ирээдүйг хариуцах түүхэн үүрэг тулгарч байна.

Та үе тэнгийн залуучууд, өсвөр үеийнхэн, нялх балчир хүүхдүүдэд ард түмнийхээ нандин чанар бүхнийг шингээж, тэднийг нийгмийн сайн сайхны төлөө тууштай тэмцэгч, шударга, хичээнгүй, хөдөлмөрч байх үзлээр хүмүүжүүлэгч байх ёстой. Энэ нь таны үүрэг зорилгын оргил нь гэдгийг байнга санаж яваарай. Хойч үе маань та бидний үргэлжлэл юм.

Та хамт олон, харилцагч нартайгаа харьцахдаа хүлээцтэй, тэвчээртэй, дүн шинжилгээтэй, эелдэг боловсон хандаж байгаарай! Хэл яриа нь та бидний зүрх сэтгэлийн дотоод мөн чанарын илэрхийлэл болдог юм шүү!



Та хамт олноосоо суралцаж байх ёстой.

Хамт олон таны түшиг тулгуур юм. Цагаан сэтгэлтэй, шулуун шударга, нөмөр нөөлөгтэй, мэдлэг боловсролтой, ажил амьдралын туршлагатай, ардын өв уламжлалыг дээдэлсэн сайхан дуурайлалтай хүмүүстэй гүн танилцаж, тэднээс байнга суралцаж яваарай.

Та үр хүүхдээ хүмүүжүүлэх үүрэгтэй.

Та үр хүүхдийнхээ гэр бүлийн хүмүүжил, ялангуяа 0-5 насны хоорондох хүмүүжилд онцгой анхаарч, хүмүүжлийн талаар ардын уламжлалт зан заншил, олон улсын жишиг сайн сайхныг шингээж өгөх ёстой. Энэ үед олсон хүмүүжил нь ирээдүйд оюун санаа, ёс суртахууны нандин чухаг бүхнийг тусган авах дэвсгэр нь болдог юм шүү!

Та их сургуулиа дээдэлж явах ёстой.

Амьдралын учир холбогдлын тухай элдвийг эргэцүүлэн бодож, ухаан суусан үе чинь таны оюутан ахуй үе юм. Наран үүрд мандаж, дэлхий дээр мөнх зун ирсэн мэт баяр баясгалантай дэгдэж явсан залуу насны чинь нэгэн агшин та нөхдийн хичээллэж, хөгжилдөн үймэлдэж байсан энэ л сургуулийн анги, танхимд шингэн үлдсэн байдаг. Төгсөгч Та МУИС-иараа овоглож, төрөлх сургууль тань төгсөгчдөөрөө бахархах болно. Иймд та сургуулийнхаа нэр төрийг өндөрт өргөж яваарай.

Бид танд тусална.

Ажил амьдралын замд чинь мэдэхгүй, чадахгүй зүйл тохиолдоно. Та лекц, сурах бичиг, гарын авлага, ажил, амьдралынхаа талаар ямар зөвлөгөө тусламж авах, мэргэжил мэдлэгээ дээшлүүлэх, их сургуулийнхаа сургалтын үйл явцыг цаашид сайжруулах талаар өөрийн санал бодлоо дуртай цагтаа чөлөөтэй илэрхийлж байгаарай. Чухамхүү үүгээр дамжин багш-шавийн, сургууль-төгсөгчдийн холбоо тасрахгүй үргэлжилнэ.

МУИС хэмээх нэг овогтой Монгол орныхоо хөгжлийг түүчээлэх Эрхэм хүндэт Та нарынхаа ажил амьдралд хамгийн сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе!